



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Түр заавар батлах тухай


Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.13, 35 дугаар зүйлийн 35.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23, 8.1.8 дах заалт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 5 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтын цэгийн бэлэн байдлыг хангах түр заавар”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтын үйл ажиллагааны халдварын сэргийлэлт, хяналтад мөрдөх түр заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан түр зааврыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Наранзул/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 03... дугаар сарын 09...-ны  
өдрийн 21.108 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ЦЭГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТҮР ЗААВАР

### Нэг. Зохион байгуулалт:

- 1.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн байгууллагууд харьяа нутаг дэвсгэрт оршин сууж байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтад хамрагдах зорилтот бүлгийн хүн амыг тодорхойлон вакцинжуулалтын төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих, бэлэн байдлын хангах, удирдан зохион байгуулах тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2. Өрх, тосгон, сум дүүргийн эрүүл мэндийн төв (ЭМТ) харьяа нутаг дэвсгэрийн зорилтот хүн ам, аж ахуйн нэгж, албан байгууллагын зорилтот бүлгийн хүн амын судалгааг гаргана.
- 1.3. Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд холбогдох байгууллагатай хамтран вакцинжуулалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө вакцинд хамрагдвал зохих хүний тоо, вакцинжуулалтын байнгын болон түр цэгийн бэлэн байдал, хүний нөөц, сургалтад хамрагдсан байдал, төлөвлөлт, хүйтэн хэлхээний чадавх зэрэгт хяналт хийнэ.
- 1.4. Дархлаажуулалтын цахим бүртгэлд мэдээлэл оруулах сувилагч, вакциначар нарыг сургаж бэлэн байдлаа ханган ажиллана.

### Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдах зорилтот бүлгийн хүн амын судалгаа

- 2.1. КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах зорилтот бүлэгт төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн ажилтан; архаг хууч, суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, 18 ба түүнээс дээш насны, орон гэргүй, асрамжийн газар амьдардаг хүн ам; хариу арга хэмжээний багт ажиллаж байгаа онцгой, цагдаа, тагнуул, хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт, төр, хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн багш, ажилтан хамаарна.
- 2.2. Архаг өвчтэй хүн амд чихрийн шижин, хавдар, уушиг, бөөр, элэгний архаг өвчин, зүрхний хүнд өвчтэй, зүрхний дутагдал, титэм судасны өвчин, кардиомиопати, даралт ихсэлт, дархлаа дарангуйлагдсан, эрхтэн шилжүүлсэн, ДОХ, кортикостеройд болон дархлаа дарангуйлах эм ууж байгаа, таргалалт (биеийн жингийн индекс-30 ба түүнээс дээш), дундаас

- хүнд хэлбэрийн багтраа, тархи судасны өвчин, сэтгэцийн эмгэг, бусад архаг халдвар бүхий хүн ам хамаарна.
- 2.3. Үйл ажиллагаа нь тасалдаж болохгүй байгууллагын судалгаанд эрчим хүч, харилцаа холбооны ажиллагсад, хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, оршуулгын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтнууд хамаарна.
  - 2.4. Зорилтот бүлгийн судалгааг байгууллага, зорилтот бүлэг тус бүрээр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо тус бүрээр гаргана.
  - 2.5. КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах хүн амын тоог зорилтот бүлэг тус бүрээр гаргаж, статистик тоотой тулган эцэслэнэ.
  - 2.6. Нэг хүнийг зөвхөн нэг зорилтот бүлгийн судалгаанд хамруулна.
  - 2.7. Аймаг, нийслэлийн ЭМГ, дүүрэг, өрхийн ЭМТ харьяа нутаг дэвсгэрт байгаа КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах зорилтот бүлэг тус бүрийн тоон мэдээг нэгтгэн гаргаж түүнийг төлөвлөлт, хяналт, вакцинжуулалтын хамралтыг тооцоход ашиглана.

**Гурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтад оролцох хүний нөөцийн төлөвлөлт ба сургалт**

- 3.1. Вакцинжуулалтын үйл ажиллагаанд оролцох хүний нөөцийн судалгааг гаргана.
- 3.2. Вакцинжуулалтын үйл ажиллагаанд дайчлан ажиллуулах хүний нөөцийн судалгаанд гавьяаны амралтад байгаа их, бага эмч, вакцинолог, сувлагч, сайн дурын идэвхтэн, МУЗН-ийн ажилтан болон бусад хүнийг оруулна.
- 3.3. Вакцинжуулах зорилтот бүлгийн хүн амын тоо, түр цэгийн тоо, байршил, вакцины хүйтэн хэлхээний онцлог, хүний нөөц зэргээс хамаарч баг тус бүрт хуваарилан баталгаажуулж багийн гишүүдэд танилцуулна.
- 3.4. КОВИД-19 вакциныг шуурхай түгээж, зорилтот бүлгийг богино хугацаанд вакцинжуулахын тулд эрүүл мэндийн байгууллага, сум, өрх, тосгон, дүүргийн ЭМТ тус бүрд дархлаажуулалтын байнгын цэгт нэг, түр цэгт хоёроос дээш баг ажиллахаар төлөвлөнө.
- 3.5. Шаардлагатай үед дайчлан ажиллах хүний нөөцөд байгаа ажилтныг татан оролцуулна.
- 3.6. Дархлаажуулалтын багийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлж үүрэгжүүлнэ.
- 3.7. Сургалтын төлөвлөгөөний дагуу багийн бүх гишүүд болон дайчлагдан ажиллах багийн гишүүдийг сургалтад бүрэн хамруулна. Шаардлагатай бол давтан сургана.
- 3.8. Халдварын өвчлөл, бусад цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сургалтыг цахим эсвэл танхимын хэлбэрээр зохион байгуулна.
- 3.9. Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Вакцинжуулалтын цэгийн бэлэн байдлыг хангах, аюулгүй байдал**

- 4.1. КОВИД-19-ын вакцинжуулалтыг өрх, сум, тосгон, дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлэг, БОЭТ, амаржих газрын заавал хийх дархлаажуулалтын өрөөнд зохион байгуулахгүй.
- 4.2. КОВИД-19-ын вакцинжуулалтын түр цэгийг байгуулахдаа зай талбай хангалттай, агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай хурлын заал, урлаг, спортын заал (цаг үеийн нөхцөл байдал буюу хөл хорио, өвчлөлийн байдал зэргээс хамаарч сургууль, цэцэрлэгийн байрыг сонгож болно) танхим, коридор гэх мэт зай талбайг ашиглана.
- 4.3. Боломжтой бол КОВИД-19-ын вакцинжуулалтын цэгийн орох гарах хаалга нь тус тусдаа байхаар, боломжгүй нөхцөлд нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулж, орох, гарах хөдөлгөөний чиглэлийн тэмдэг тэмдэглэгээг хийнэ.
- 4.4. Вакцинжуулалтын түр цэг нь хүлээлгийн хэсэг, вакцинжуулалтын хэсэг, ажиглалтын гэсэн тусдаа хэсэгтэй байна.
- 4.5. Вакцинжуулалтын түр цэгүүдэд 1.5-2 метрийн зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх, гар угаах зэрэг санамж, зурагт хуудсууд, сургалт, сурталчилгааны материалыг байрлуулна.
- 4.6. **Хүлээлгийн хэсэгт** QR код, гар угаах угаалтуур/гар халдваргүйжүүлэгч, хүн хооронд 1.5-2 метрийн зай барих тэмдэглэгээ, сандал, вакцинжуулалтын хэсэгт зөвхөн 1-2 хүн орох анхааруулга, зайнаас халуун хэмжигчийг бэлэн байлгана.
- 4.7. **Вакцинжуулах хэсэгт** бүртгэгч, эмч, вакциатор байрлана.
- 4.8. Эрүүл мэндийн ажилтанд зориулсан гар угаах угаалтуур/гар халдваргүйжүүлэгч, амны хаалтын нөөц хангалттай байна.
- 4.9. Эмч, вакциаторын ширээ хоорондын зай 2-3 метрээс доошгүй байхаар байрлуулна.
- 4.10. Вакцин хийлгэх хүнийг суулгах сандал бэлтгэнэ.
- 4.11. Боломжтой бол эмчийн үзлэгийн хэсгийг хаалтаар тусгаарлана.
- 4.12. Вакцинжуулалтын өрөөнд дараах зүйлийг бэлэн байлгана. Үүнд:
  - Мөсөн элемент бүхий вакцин зөөврийн сав
  - КОВИД-19 вакцин, дагалдаж ирсэн уусгагч шингэн
  - Өөрөө эвдэрдэг найруулах тариур
  - Өөрөө эвдэрдэг тарих тариур
  - Аюулгүй хайрцаг
  - 70% денатурат спиртийн уусмал
  - Ариутгасан хөвөн бөмбөлөг
  - Тун шил (ампул) хөрөөдөгч
  - Нэг удаагийн ариун бээлий (шаардлагатай тохиолдолд)
  - Наалдуулагч лент
  - Гар халдваргүйжүүлэгч, амны хаалт
  - ДДУХ/Анафилаксийн үед хэрэглэх багц
  - Хог хаягдлын уут, сав
  - Эмч, вакциатор бүр компьютертэй байх

- Хэвлэгч
- Хүчилтөрөгчийн дэр/хүүдий
- Пульсоксиметр
- Тарианы тэргэнцэр
- Бүртгэл, мэдээллийн маягт
- Шаардлагатай утасны жагсаалт хэвлэж тавих

- 4.13. **Ажиглалтын хэсэгт** вакцин хийлгэсэн нэг хүн 20-30 минут байх тул аль болох зай талбай хүрэлцээтэй, хангалттай өрөө, тасалгаа, зай талбайг сонгож, суух сандал байрлуулна.
- 4.14. Ажиглалтын хэсэгт хүн хоорондын зайг 1.5-2 метр байхаар тооцож тэмдэглэгээ хийх, гар халдваргүйжүүлэх, амны хаалт зүүх, зай барих, вакцин тариулсаны дараа илэрч болох урвалын талаар сурталчилгааны материал, гар халдваргүйжүүлэх бодис, сандал зэргийг байрлуулна.
- 4.15. Вакцинжуулалтын түр цэгийн аюулгүй байдлыг холбогдох тушаал, зааврын дагуу холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

**Тав. Вакцинжуулалтын багийн үүрэг:**

- 5.1. Баг нь их эмч, вакцинолог, сувилагч, зохицуулагч, бүртгэгч, жолооч, үйлчлэгч нарын бүрэлдэхүүнтэй ажиллана. Шаардлагатай үед жолооч, үйлчлэгч, мэдээллийн ажилтан ажиллана.
- 5.2. Шаардлагатай үед багт ажиллах гишүүний тоог нэмнэ.
- 5.3. Түр цэг байгуулсан тухайн байгууллага нь зохицуулагч, бүртгэгч, үйлчилгээний ажилтан, мэдээллийн ажилтан, халдваргүйтгэгч/ариутгагчийг томилж ажиллуулна.
- 5.4. Байгууллага вакцинжуулалтын бэлэн байдлаа хангах ажлын хэсэг/багийг томилж ажиллуулна.
- 5.5. Байгууллагаас томилогдсон **зохицуулагчийн үүрэг:**
- 5.5.1. КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах ажилтны судалгааг зааврын дагуу гаргана.
  - 5.5.2. Түр цэгийн бэлэн байдлыг хангана.
  - 5.5.3. Вакцинжуулалтаас хоцорсон ажилтны судалгааг гаргаж нөхөн дархлаажуулах ажлыг ӨЭМТ-тэй хамтран гүйцэтгэнэ.
  - 5.5.4. Хуваарийн дагуу, халдвар хяналтын дэглэмийг сахин, эмх замбараатай, бөөгнөрөл үүсгэхгүйгээр вакцинжуулалтыг зохион байгуулна.
  - 5.5.5. Хүлээлгийн өрөөнд орохоос өмнө ажилтан/ вакцин хийлгэхээр ирсэн хүмүүсийн биеийн халууныг хэмжинэ. Хэрэв халуунтай байвал хүлээлгийн өрөө рүү оруулахгүйгээр холбогдох арга хэмжээг авна.
- 5.6. **Бүртгэгчийн үүрэг:**
- 5.6.1. Тухайн байгууллага нь бүртгэгчийг томилон ажиллуулна.
  - 5.6.2. Бүртгэгч зорилтот бүлгийн хүн амыг вакцинжуулалтын өрөөнд орохын өмнө урьдчилан гаргасан бүртгэлтэй тулгана.

5.6.3. Бүртгэгч вакциначтортай хамтран хамралтын мэдээг гаргана.

**5.7. Эмчийн үүрэг:**

- 5.7.1. КОВИД-19 асуумжийг хүн тус бүрээс асууж бөглөнө. (Дархлаажуулалтын цахим бүртгэлийн хэсэгт байгаа)
- 5.7.2. Эмчийн үзлэг, оношийн хэсгийг бичиж, вакцинд хамрагдах эсэх талаарх сонголтыг програмд хийнэ.
- 5.7.3. Хэрэв дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл илэрвэл яаралтай тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 5.7.4. Яаралтай тусламж үйлчилгээний багц, шаардлагатай багаж хэрэгслийг бэлэн байлгана.
- 5.7.5. Вакцины дараа илрэх урвал хүндрэлийн талаар зөвлөгөө өгнө.

**5.8. Вакциначтор/сувилагчийн үүрэг:**

- 5.8.1. КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах тухайн хүнийг регистрийн дугаараар дархлаажуулалтын цахим бүртгэлээс хайна.
- 5.8.2. Эмч тухайн хүнийг вакцинд хамруулах заалт бичсэн эсэх талаар цахимаас харж шалгана.
- 5.8.3. Холбогдох зааврыг баримтлан тухайн хүнд вакцин тарина.
- 5.8.4. Цахим бүртгэлд КОВИД-19-ын эсрэг вакцин хийлгэсэн талаарх мэдээллийг оруулна.
- 5.8.5. Тухайн хүнийг ажиглалтын өрөөнд 20-30 минутын хугацаанд үлдэхийг сануулж, зөвлөгөө өгнө.
- 5.8.6. "КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдсан гэрчилгээ"-г дархлаажуулалтын цахим бүртгэлээс хэвлэж өгнө.

**5.9. Бусад ажилтны үүрэг:**

- 5.9.1. Үйлчлэгч вакцинжуулалт хийхийн өмнө, дууссаны дараа, шаардлагатай үед цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухай бүр хийнэ.
- 5.9.2. Жолооч вакцинжуулалтын байнгын, түр цэгүүдэд вакцин, дагалдах хэрэгслийн түгээх ажлыг холбогдох ажилтантай хамтран хариуцна.
- 5.9.3. Цагдаагийн ажилтан нь вакцины тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

**Зургаа. Вакцинжуулах стратеги**

**6.1. КОВИД-19-ын вакцинжуулалтын цэг:**

- 6.1.1. Дархлаажуулалтын байнгын нэгжтэй эрүүл мэндийн байгууллага ажилтнаа КОВИД-19-ын эсрэг вакцинд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.1.2. Харьяа нутаг дэвсгэрт байгаа КОВИД-19-ын эсрэг вакцинд хамрагдах бусад зорилтот бүлгийн хүн ам буюу ахмад настан, архаг хууч, суурь

өвчтэй хүн ам, хөгжлийн бэрхшээлтэй, орон гэргүй, бусад зорилтот бүлэг, хүн амыг вакцинжуулна.

- 6.1.3. КОВИД-19-ын өвчлөл, зорилтот бүлгийн хүн амын байршил, тоо, ажиллах хүний нөөц, цаг үеийн бусад нөхцөл байдалтай уялдуулан вакцинжуулалтын цэгүүдийн зохион байгуулалт, үйл ажиллагааг нэгтгэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.
- 6.1.4. Дархлаажуулалтын нэгжгүй эрүүл мэндийн байгууллага харьяа өрх, тосгон, сум дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран вакцинжуулалтын түр цэг байгуулан бэлтгэлийг хангаж ажилтнаа КОВИД-19-ын эсрэг вакцинд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.1.5. Бусад аж ахуйн нэгж, албан байгууллага нь харьяа өрх, тосгон, сум дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтарч түр цэг байгуулан бэлтгэл ажлыг ханган вакцинжуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

## **6.2. Явуулын вакцинжуулалтын баг:**

**6.2.1.** Хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй зорилтот бүлгийн хүн амыг вакцинжуулах ажлыг явуулын баг зохион байгуулж болно.

## **Долоо. Зураглал гаргах**

- 7.1. Дархлаажуулалтын нэгж бүхий эрүүл мэндийн байгууллага нь газарзүйн байршил, хүний нөөц, хүйтэн хэлхээний чадавх, дархлаажуулалтын байнгын, түр цэгийн байршил, зай, зорилтот бүлэг, хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй газар, хүн ам гэх мэт мэдээллийг багтаасан зураглалыг гаргаж вакцинжуулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд ашиглана.

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 05 дугаар сарын 09-ны  
өдрийн 7408 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

## КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТАД МӨРДӨХ ТҮР ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. КОВИД-19 халдварын вакцинжуулалтыг дархлаажуулалтын нэгж, түр болон явуулын цэгээр хийх үйл ажиллагаанд энэхүү зааврыг баримтална.
- 1.2. Энэхүү зааварт тусгагдаагүй үйл ажиллагааг эрүүл мэндийн сайдын 505 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлын менежментийн журам, зааврыг мөрдөж ажиллана.
- 1.3. Вакцинжуулалтад хамрагдаж байгаа иргэнийг болон эрүүл мэндийн ажилтан өөрийгөө халдварын эрсдэлээс сэргийлж, эрүүл мэндийн ажилтан нэг удаагийн халад, амны хаалт тогтмол хэрэглэж, гарын эрүүл ахуйг сахиж халдвараас сэргийлэх стандарт дэглэмийг хэрэгжүүлнэ. Үйлчлүүлэгчид амны хаалт зүүхийг зөвлөнө.

### Хоёр. Вакцинжуулалтын цэгийн зохион байгуулалт:

- 2.1. Вакцинжуулалтын цэг нь вакцинжуулалтын өрөө болон хүлээлгийн, ажиглалтын, ажилтны хувцас солих, хувцас тайлах, бүртгэл хийх хэсэгтэй байхаар зохион байгуулна. Боломжтой бол орох болон гарах 2 хаалга тусдаа байхаар зохион байгуулна. Хэрэв орох гарах хаалга тусдаа байх боломжгүй нөхцөлд нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулна.
- 2.2. Вакцинжуулалтын цэгийн бүх өрөө нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, агааржуулалт сайтай, аль болох бохир, цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон, халаалттай байна.
- 2.3. Өрөө нь гарын угаалтууртай, шингэн саван, гар арчих нэг удаагийн алчууртай байна.
- 2.4. Вакцинжуулалтын цэгт эсвэл вакцинжуулалтын цэгийн ойролцоо үйлчлүүлэгч ашиглах боломжтой гар угаах угаалтуур бүхий ариун цэврийн өрөө, бие засах газартай байна.
- 2.5. Хүлээлгийн болон ажиглалтын хэсэгт үйлчлүүлэгч хооронд 1.5-2-ээс доошгүй метрийн зай барих боломжтой, зай барих, амны хаалт хэрэглэх,



ханиаж, найтаахдаа ам, хамраа бүрэн дарахыг сануулсан зурагт хуудас бүхий санамж анхааруулга, хогийн сав зэргийг байршуулсан байна.

- 2.6. Вакцинжуулалтын өрөөнд 2 цаг тутамд 10-15 минут салхивч нээж агааржуулалт хийнэ.

#### **Гурав. Вакцинжуулалтын үеийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаа:**

- 3.1. Вакцинжуулалтыг хийх эрүүл мэндийн ажиллагсад нь амны хаалт, нэг удаагийн халад, нүүрний хаалт өмсөж ажиллана.
- 3.2. Нэг удаагийн үзлэгийн бээлий өмссөн бол хүн хооронд солино. Нэг хүнд ашигласан бээлийг дараагийн хүнд дамжуулж хэрэглэхгүй.
- 3.3. Хамгаалах хувцас илт бохирдоогүй, урагдаж цоороогүй, нороогүй бол тасралтгүй 4 цаг хүртэл хугацаагаар хэрэглэж болно.
- 3.4. Хувцас тайлах хэсэгт дараалал, толь байршуулна.
- 3.5. Вакцинжуулалтын өрөө, бүртгэх хэсэг, хувцас тайлах хэсэгт гар халдваргүйжүүлэх бодисыг байршуулсан байна. Гар халдваргүйжүүлэх бодис нь шахуурга бүхий савлагаатай байна.
- 3.6. Гарын ариун цэвэр сахих 5 заалтыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.7. Вакцинжуулалтын үед ашигласан халдварын эрсдэл багатай даралтын аппарат, чагнуур, халууны шил, пульсоксиметр зэрэг багаж хэрэгслийг үйлчлүүлэгч хооронд 70 хувийн спирттэй хөвөн, эсвэл зориулалтын халдваргүйжүүлэх бодистой салфеткаар арчиж халдваргүйжүүлнэ.
- 3.8. Өрөө тасалгаанд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхдээ дараах зарчмыг баримтална.
  - 3.8.1. Өдөрт 2-оос доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
  - 3.8.2. Цэвэрлэсний дараа халдваргүйжүүлнэ.
  - 3.8.3. Халдваргүйжүүлэлтийг арчиж хийнэ. Гар шүршигч ашиглаж байгаа үед зай талбай үлдээхгүй хэсэг хугацаанд чийгтэй байхаар тооцож хангалттай хэмжээгээр шүршээд алчуураар тарааж арчина.
  - 3.8.4. Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зөвшөөрөлтэй бодисыг сонгож орчны халдваргүйжүүлэлтэд ашиглана.

Түгээмэл хэрэглэдэг бодисыг дараах концентрацаар найруулж хэрэглэж болно. Үүнд: Гипохлорт натри 0.1%, 0,5%, Жавелион 0.015%, 0.03%, Хлорсепт 0.02-0.1% гэх мэт.
  - 3.8.5. Бодисын үйлчлэх хугацааг барина.

3.8.6. Цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийхдээ хамгаалах хувцас өмсөнө. Ахуйн бээлийг ажил дууссаны дараа халдваргүйжүүлэх уусмалд дүрж халдваргүйжүүлээд тайлна.

#### **Дөрөв. Вакцин тарилгын аюулгүй байдал**

- 4.1. Вакцин хийхдээ нэг хүнд нэг удаагийн өөрөө эвдэрдэг зүү тариурыг ашиглана. Хэрэв найруулж хэрэглэдэг вакцин бол найруулахад ашигласан нэг удаагийн зүү, тариурыг давтан хэрэглэх, вакцин найруулахад дахин ашиглахыг хориглоно.
- 4.2. Туншлыг нээхийн өмнө задлах хэсгийг, мөн тарилгын уусмалыг найруулж бэлтгэхдээ зүү хатгах хэсгийг халдваргүйжүүлнэ.
- 4.3. Арьсны талбайн халдваргүйжүүлэлтэд ариун хөвөн, самбайг 2%-ийн хлоргексидин, 70%-ийн спирт, эсвэл 2.5-7.5%-ийн повидон иодын уусмалд шингээж ашиглана.
- 4.4. Талбайд халдваргүйжүүлэлт хийснээс хойш 30 секунд орчмын дараа зүүг хатгана.
- 4.5. Хатгалт хийх талбайд хэт их бохирдолттой бол халдваргүйжүүлэлт хийлгэсний дараа савандаж угаалгана.
- 4.6. Халдваргүйжүүлэлтийн дараа хатгалт хийх талбайг бохирдуулахаас сэргийлж гараа хүргэхгүй байх, бохирдуулах эрсдэлтэй бусад зүйлийг хүргэж болохгүй.
- 4.7. Зүүг хатгалт хийх хүртэл хамгаалалтын тагтай байлгана. Бохирдох эрсдэл үүссэн бол зүүг солино.
- 4.8. Вакцин хийсэн талбайг бохирдлоос сэргийлж ариун самбайгаар дарж наалтаар тогтооно. Талбайн халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн хөвөнг тарилгын дараа ашиглаж болохгүй, ариун хөвөн ашиглана.
- 4.9. Вакцинжуулалтын явцад тарианы тэргэнцэр, тавиур, вакцин бэлтгэх талбайг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

#### **Тав. Хог хаягдлын менежмент**

- 5.1. Вакцинжуулалтын үед гарсан хог хаягдлыг цуглуулах, зөөх, түр хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалыг мөрдөнө.
- 5.2. Вакцинжуулалтад явцад үүссэн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, тарианы хөвөн, вакцин, вакцины флакон, нэг удаагийн зүү, тариур зэрэг хог хаягдлыг аюултай хог хаягдалд тооцож ангилан ялгана.
- 5.3. Вакцинжуулалтын өрөөнд халдвартай хог хаягдал цуглуулах "Биоаюултай" таних тэмдэг бүхий шар өнгийн уут, аюулгүй хайрцаг, энгийн хог хаягдал

цуглуулах хар өнгийн уут, хувцас тайлах хэсэгт халдвартай хог хаягдал цуглуулах "Биоаюултай" таних тэмдэг бүхий шар өнгийн уут тус тус байршуулна.

- 5.4. Аюулгүй хайрцаг нь хурц үзүүр иртэй хэрэгсэл нэвтэрч гарахгүй, шингэн нэвчихгүй байх шаардлага хангасан байна.
- 5.5. Хамгаалах хувцас хэрэгсэл тайлахдаа хогны уут дүүрсэн үед дээрээс нь чихэх, дарах үйлдлийг хийхгүй. Хувцас тайлах хэсэгт байх хог хаягдлын уут нь 50 литрээс дээш хэмжээтэй (өргөн 50см, урт нь 80см дээш) байх ба "Биоаюултай" таних тэмдэгтэй, автоклавдах боломжтой байна.
- 5.6. Зүү, тариур, хагарсан ампул зэрэг хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг "Аюулгүйн хайрцаг"-т, хөвөн шарик, вакцины флакон, хэрэглэсэн хамгаалах хувцсыг халдвартай хог хаягдал цуглуулах шар өнгийн уутанд цуглуулна.
- 5.7. Хог хаягдлыг нэг уутнаас гаргаж нөгөө уут руу дахин савлаж хийхгүй.
- 5.8. Хог хаягдлыг зөөх, тээвэрлэх, устгахад оролцож байгаа ажилтан нэг удаагийн халад эсвэл комбинезон, малгай, нэг удаагийн амны хаалт, нүүрний хаалт, резинэн бээлий, ажлын гутал өмсөнө.
- 5.9. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг битүүмжлэл сайтай, тагтай, бариултай сав, эсвэл дугуйтай тэргэнцэрт хийж зөөвөрлөнө. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгт төвлөрүүлнэ.
- 5.10. Түр хадгалах цэгээс шатаах цэг хүртэл машинаар тээвэрлэнэ. Хог хаягдал тээвэрлэх тусгай машинтай байна.
- 5.11. Вакцинжуулалтын явцад үүссэн халдвартай болон хурц үзүүр иртэй хог хаягдлыг автоклаваар халдваргүйжүүлж хог хаягдлын цэгт ландфиллын аргаар булж устгана.
- 5.12. Хамгаалах хувцас, хэрэгслийн хог хаягдлыг хүн амын суурьшлын бүсээс гадна, хог хаягдлын цэгт шатааж устгана. Бүрэн шатсан эсэхэд хог хаягдлын ажилтан хяналт тавина.
- 5.13. Хог хаягдал зөөх сав, тэргэнцэр, жин, тээвэрлэсэн машин зэргийг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.